

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 12/370

НШУС

2011

ЭРДЭМТЭН-СЭТГҮҮЛЧ Ж.ЦЭВЭЭНИЙ НЭГЭН БҮТЭЭЛИЙН ТУХАЙ

Н.Ариунзаяа*

* «Соёл эрдэм» дээд сургуулийн багш, сэтгүүл зүйн доктор (Ph.D.)

Түлхүүр үг: соён гэгээрүүлэгч, бичиг захидал, цагаан сурэг, орчлонт ертөнц, эцэг, зурхай, дооромбо

ХХ зууны Монголын нэért соён гэгээрүүлэгч, эрдэмтэн, сурган хүмүүжүүлэгч, сэтгүүлч, улс төрийн зүтгэлтэн Ж.Цэвээний нэрийг эргэн дурсаж, намтар түүх, бүтээл туурвилиг эрж хайх болсон нь ардчилсан нийгмийн нехцөлд хүний үзэл бодол, сэтгэлгээ чөлөөлөгдөж байгаагийн нэг жишээ юм. Барууны үзэл сурталч, Японы тагнуулын хорлон сүйтгэх ажиллагааны удирдагч, «Япон-Буриадын төв» хэмээх хувьсгалын эсэргүү байгууллагын толгойлогч гэх мэт нэр хоч зүүж гадуурхагдан Монголоос дүрвэж, Оросд цаазаар авахуулсан түүний бүтээл туурвилиг саяхан болтол сонирхон судалдаггүй байлаа. Тухайн үед ном бүтээлд нийтлэгдэж нийтийн хүртээл болсноос бусад, ялангуяа эрдэм шинжилгээний холбогдолтой материал, элдэв хүнтэй харилцсан бичиг захидал зэрэг үнэ цэнтэй асар олон баримт бидэнд өвлөөгүй юм. Ганц жишээ дурдахад Ж.Цэвээнийг 1937 оны 8 дугаар сарын 11-нд Ленинград хотноо баривчлагдахад гэрт нь байсан 22 дэвтэр бүхий тэмдэглэлийг Аюулаас хамгаалах байгууллага хураан авч шатаасан баримт байна. Түүнээс гадна гучаад оны эхээр хавчлага дарамтын эрхээр гэр орон, авааль эхнэрээ хүртэл орхиод Монголоос ум хумгүй гарч явахад нь ямар үнэ цэнтэй, хичнээн

бүтээл, баримт бичиг үрэгдэж үгүй болсныг тооцох аргагүй.

Ж.Цэвээний түүхэн гавьяаг бодитой үнэлж, зохих байранд нь тавих үйлсэд сэтгүүлч, сэтгүүл зүй судлаачид бусдаас илүү үүрэг гүйцэтгэсэн байdag. Анх доктор Г.Дэлэг үзэл суртлын хатуу хориг чандлагатай байх үед бичсэн «Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл» гэдэг бүтээлдээ Ж.Цэвээний сэтгүүлчийн үйл ажиллагаа хийгээд түүний эрхэлж байсан «Шинэ толь хэмээх бичиг» сонины тухай бууртай шинжилгээ хийсэн юм. Түүний дараа сэтгүүл зүй судлаач доктор, профессор Л.Норовсүрэн 1993 онд нийтлүүлсэн «Түүхэн үнэнийг хүндэтгэе»¹, 1996 онд нийтлүүлсэн «Ж.Цэвээн — Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн»² гэх зэрэг өгүүллүүддээ Ж.Цэвээний Монголын сэтгүүл зүйг үндэслэгч мөн, түүний гаргаж байсан «Шинэ толь хэмээх бичиг» сонин чөлөөт ардчилсан хэвлэл байсан гэдэг дүгнэлтүүдийг анх түрүүнд хийсэн байdag. Тэр дүгнэлттэй сүүлийн үед судлаач Т.Баасансүрэн дуу хоолойгоо нэгтгэж нэг сэдэвт цуврал зохиолдоо³ дэлгэрүүлэн бичсэн байна. Өнгөрсөн хугацаанд доктор С.Лочин, Ж.Цэцэгмаа, С.Идшинноров, Ч.Дашдаваа, судлаач Б.Шагдаржав, Б.Авид нарын зэрэг хүмүүс Ж.Цэвээний эрдэм шинжилгээ, уран бүтээлийн өвийг судалсны дотор С.Идшинноров их соён гэгээрүүлэгчийн бүтээлийг сурвалжлан эмхтгэж хоёр дэвтэр болгон хэвлүүлсэн⁴ нь Цэвээн судалалын эх

суурийг тавьсан буянтай ажил болсон юм.

Дээрх судлаачдын эрэл хайгуулын үр дүнд Ж.Цэвээний нилээд бүтээл шинээр олдож судалгааны эргэлтэд орсон байна. Тухайлбал доктор Т.Баасансүрэнгийн идэвх чармайлтаар «Өргөө орохдоо бичсэн тэмдэглэл» (1904), «Цагаан сүргийн их тайлга» (1910) зэрэг нийтлэлийн бүтээлүүд нийтэд түгжээ.

Судлаач миний бие ХХ зууны эхэн үеийн Монголын нийгэмд ихээхэн шуугиан тарьсан нэгэн бүтээлийн тухай цуhas дурдахыг хүслээ. Тэр бол «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» хэмээх багашаархан ном мөн. Монгол оронд жинхэнэ бодисыг баримталсан шинэ цагийн шинжлэх ухааны анхны бүтээл болсны хувьд тэр ном үнэ цэнтэй юм. Уг номын зохиогч нь Ж.Цэвээн, Буяндалай нар байжээ. Монголчууд Манжийн дарлалыг эсэргүүцэн босч туурга тусгаар улсаа байгуулсны дараа шинэ цагийн сургууль боловсролыг эрхлэх болсон үед хүүхэд багачуудад үзүүлэх ном дэвтэр чухал болсон байна. Энэ шаардлагаар уг номыг бага сургуулийн заан сургах бичгийн чанартайгаар түүрвн бүтээжээ.

Ж.Цэвээн Монгол улсын боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл мэдээллийн салбарыг үүсгэн хөгжүүлэхэд гарамгай үүрэг гүйцэтгэж ХХ зууны эхэн үеийн Монголын оюун ухааны “эцэг” гэгдсэн хүн байв. Тэрбээр шинэ тутам үүсч хөгжик байгаа сургууль тэнхмүүдэд зориулж гол төлөв байгалийн шинжлэл, түүхийн чиглэлээр орчуулах, өөрөө зохиохыг хослуулан нийтдээ 13 нэрийн сурах бичиг, гарын авлага зохиосны анхных нь энэхүү «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» юм. Уг номыг хамтран зохиогч нь сартуул дооромбо Гэлэгжамц буюу Монголчилбол Буяндалай гэдэг тухайн үеийнхээ шашны сургуультнуудын дундаас тодорсон дэвшилт үзэлтэй нэгэн байв. Буяндалай энэтхэг, төвд хэл

бичигт нэвтэрхий хүн байжээ. Тиймээс ч энэтхэг, төвд ёсны «Зурхай» буюу одон орныг хэмжих сургаалын зүйлийг судалж, одон гариг зэргийн монгол нэрийг нэвтэрхий мэдэх болсны хувьд Европ зүгийн нэр, ухагдахууныг монгол бичгийн хэл, судрын хэлнээ бүхий нэртэй хэрхэн дүйлгэн онох үлэмжжэн бөгөөд хучир ажлыг хийхэд Ж.Цэвээнд итгэмжит нөхөр нь болсон байна. Буяндалай 1921 оны хувьсгалын дараа Судар бичгийн хүрээлэн байгуулахад анхны гишүүн нь болж, монгол хэл бичгийн ном зохиол цуглуулах, орчуулах зэргээр ажиллаж байжээ. Тэрбээр Монгол оронд байдаг эрдэнийн чулуу, ургамал, цэцэг навч мэтсийн нэр томьёог төвд хэлнээс монголчилсон нь өнөө хэр Улсын төв номын санд бий. Буяндалайг ийнхүү шинэ цагийн шинжлэх ухаанд хүчин зүтгэж эхэлсэн Гандангийн том лам нар ихэд дургүйцэн «Тэр нөхөр Хүрээлэнд ажил хийх гэж гүйдэг нь янчааны хойноос гүйсэн хэрэг. Тэр одоо Гэлэгжамц дооромбо биш, Янчаан дооромбо боллоо» гэж муулдаг болсон гэх хууч яриа байдаг. Ертөнцийн үүсэл гарал, байр байцын тухай шинжлэх ухааны үзлийг Монголд анх удаа дэлгэрүүлсэн тэр ном Европ зүгт боловсруулсан сайхан зураг хөрөгтэйгээр хэвлэгдэж бага сургуулийн олон танхимд хэрэглэгдэхийн зэрэгцээгээр монгол бичигтэй албаны болон жирийн иргэд ихэд сонирхон худалдан авч үздэг эрэлт хэрэгцээтэй зүйл болсон байна.

Уг номын үзэл санаа тэр дорхноо олонд түгэж, дэлхий ертөнцийн талаарх хэвшиж дадсан ойлголтыг эвдэж байгаад шашиыхан ихэд дургүйцэж эхэлжээ. Тэдний үзэл номлолд «Дэлхий гурвалжин хэлбэртэй. Нар сүмбэр уулыг эргэн тойрдог учраас өдөр, шенэ ээлжилдэг. Сарыг Рааху гэдэг шумнаас залгидаг учир хиртдэг» гэх мэтээр сургасан байдаг. Гэтэл «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» гэдэг бүтээлд дэлхий бол бөмбөрцөг юм, тэр бөмбөрцөг нарыг тойрон

эргэдэг гэсэн цоо шинэ ойлголтыг төрүүлж «Манай энэ суугаа ертөнцийн орны дүрс байдал нь бөөрөнхий бөгөөд хийн бүрхэвчтэй, хүрд мэт өнхрөн эргэнэ. Өдөр шөнөд нэг удаа эргэнээр энэ мэт явж нарыг нэгэнт тойрч гүйцвэл нэг жил гэнэ. Бөөрөнхий ертөнцийн орны нарны зүг хандсан талыг өдөр хэмээн, нөгөө сүүдэр этгээдийг шөнө гэнэ. Сар нарыг нэг удаа тойрон эргэж гүйцвэл нэг сар болов гэнэ. Бас нэг удаа өнхрөн өдөр шөнийн 24 цаг өнхөрч нэг хоног болно.

Бөөрөнхий газрын нарны зүг чиглэсэн хувийг халууны орон гэх, түүний хойд талыг сэргүүний орон гэж, бас урд, хойд хоёр оройг хүйтэн орон гэнэ. Манай Монгол орон дэлхийн бүслүүр дэх халуун орны хойд этгээдийн сэргүүн оронд байна. Халуун оронд бол хүний сүүдэр доош хандаж толгой дээгүүр нар эргэнэ» гэх мэтээр бичсэн байна.

Уг ном зөвхөн Ар Монголд төдийгүй өвөрлөгчдийн дунд өргөн тархаж сургууль соёлын газарт үзэж судлан, сонин хэвлэлд ч хэсэглэн нийтэлж байсан бололтой байна. Түүний наад захын жишигээнд 1918 оны үед Хятадын Зүүн хойд мужид гарч байсан «Мүгдэнгийн монгол сэтгүүл»-д уг номын хэсгээс нийтэлснийг дурдаж болно. Хамгийн сонирхолтой нь хэсэглэн авсан тэр нийтлэлд Ж.Цэвээний эрхлэн гаргаж байсан «Шинэ толь хэмээх бичиг» сонины уриа болох «Түмэн зүйлийг бадруулж, элдэв ухааныг нэвтрүүлмой» гэдгийн «Элдэв ухааныг нэвтрүүлмой» гэснийг бараг тэр янзаар нь гулсуулан авч «Элдэв ухааныг бадруулан нэвтрүүлэх нь» гэсэн гарчиг өгч нийтэлсэн явдал мөн. Тэр нийтлэл шууд «Тавдугаар» гэж эхэлж байгаа нь «Орчлон ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр»-ээс цувралаар нийтэлж байжээ гэх бидний үзлийг лавшуулж байгаа юм. «Мүгдэнгийн монгол сэтгүүл»-д нийтлэгдсэн тэр хэсэг нь «Тавдугаар. «Хүйтэн, халуун, салхи, өвөл, хур бороо, цас

тэргүүтний учир». Манай бөөрөнхий дэлхий дээр нарны гэрэл хэдүй эгц тусваас төдий халуун байх тул зэргээр халуун, сэргүүн, хүйтний улиралт орон хэмээн ялгамуй. Мөн халуун, хүйтэн хоёрт шүтэж салхи хөдлөх, салхинд дагагдаж үүл явах, сэргүүнээс үүлэн доторх усны уур нийлэлдэж борооны дусал болон буух ба хүйтнээс усны уур нийлэлдэн хөлдөж цасан болж унамой. Ер хүйтэн, халуун хоёр хийнээс халуун нь хөнгөн, хүйтэн нь хүнд. Үлгэрлэвээс өвөл цагт дулаан байшингийн үүд нь үүдний дээд захаар гадагшаа гарч, гаднах хүйтэн доорд талаар дотогш шурган ордог ёсыг хэн ч мэдмүй. Хэрэв үүдний дээд захад зул барьж үзвээс дөл нь гадагш хөөгдмүй. Мөн доорд талд бариваас дөл нь дотогшоо хэлбиймүй. Үүдний дунд бариваас дээш ноцмой.

Дэлхий дээрх салхины хөдлөх нь үүн лүгээ адил. Халуун орны хий дээш хөөрч оронд нь хүйтэн орны хий урсаж сэргүүнээр салхилмой. Бас ажиглаваас хуурай газар халах, хөрөх нь түргэн, ус болбаас халах, хөрөх удаан тул далайн эрэг дээрх газрын хий нь өдөр болбаас тэргэн халж дээш хөөрөн, оронд нь далай дээрх сэргүүн хий урсан ирмүй. Шөнө болбаас мөн газар нь түргэн хөрч, далайн ус хөрөх удаан тул дээрх бүлээн хий нь дээшээ хөөрөн, оронд нь хуурай газар дээрээс сэргүүн салхин ирмүй⁵ гэжээ. Энэхүү өгүүлийг бичигчид тус сэтгүүлийн бүх дугаарыг үзэх боломж байсангүй. Энэхүү 15 дахь дугаараас хойш дараалсан таван дугаарыг шүүж үзэхэд цувралын үргэлжлэл нийтлэгдээгүй байв. Үүнээс үзвэл «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр»-ээс авсан уг цуврал нийтлэлийг хоорондоо нилээд зйтай буюу сэтгүүлд зайд талбай хүрэлцээтэй байх үед самбаачлан оруулдаг байсан бололтой.

«Бидний номыг анх гарахад Хүрээний лам нар маш их дургүйцэж, буруу номын үзэл тараалаа, бурхан шашны

ном ёсонд таарахгүй юм хийлээ гэж ихэд цуу дамнадаг байлаа» хэмээн Цэвээн авхай дурсан ярьдаг байсан гэж академич Б.Ринчен тэмдэглэсэн байdag.

Шашныхан уг номыг ам хэлээр эсэргүүцэхийн зэрэгцээ устгаж үгүй хийх далд хорон санаа агуулж, башир арга сэдэж байсан баримт ч байdag. «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» гэдэг номыг Хүрээний залуу лам банди нар их сураглаж, худалдан авах болсонд Ж.Цэвээн нар ихэд олзуурхаж, “бага залуу лам нар шинэ цагийн боловсролыг сонирхох болж” хэмээн бодож байжээ. Гэтэл нэг өдөр тэр номыг нэг лам банди сураглан ирж худалдан авах зуур санамсаргүй “Чи монголтой юм уу?” гэж асуухад цаад банди нь “Би монгол мэдэхгүй” гэж гэнэ. “Тэгвэл чи яаж энэ монгол үсгийн номыг үзэх гэж байгаа юм бэ?” гэж асуусанд цаад банди нь гэнэн хүн байсан учир “Би унших гэсэн юм биш ээ. Манай зурхайч багш буруу номын бичиг гарлаа. Түүнийг худалдаж аваад шатаавал буян хураана гэж айлдсан юм. Би хөрөнгө нимгэн тул олон ном худалдан авч дийлэхгүй боловч, нэгийг ч гэсэн худалдан авч, шатаан устгаж багшийн зарлиг тааллыг дагая гэж яваа билээ” гэж үнэн учраа хэлчихжээ. Ингэж уг номын нилээд хэсэг шатаж устсаныг мэдсэн байна.

«Шинэ толь хэмээх бичиг»-ийг залгамжлан 1915 оноос эхэлж гарсан «Нийслэл хүрээний сонин бичиг»-ийн анхны дугаарт нийтэлсэн нэг сонордуулга анхаарал татаж байгаа юм. Түүнд «Дэлхий дээр байдал дүрс, зан суртал нь Орос, Хятад лугаа адилгүй хүн, албаттай газар орон олон буй тул өдгөө Гадаад Монгол автономит болсон учир олон монголчууд энэ зүйлийн учрыг мэдэх нь чухал бөгөөд саяхан манай хорооны газраа Цэвээн Жамсраногоос “Ертөнцийн байдал” хэмээх дэвтэр шинэ зохиол гаргасан бөгөөд энэхүү дэвтрийг үзэхэд маш сонин ба олон түшмэд үзэж мэдвээс

санаанд авах сургаал олон буйн дээр тэрхүү дэвтэрт газар дэлхийн байдал, уулуудын тогтсон ба далай, гол, арал уулсын нэр зэрэг сонин зүйл олон бөгөөд газрын ерөнхий төлөвийн зураг бас буй бөгөөд, өдгөө хүртэл монгол газраа энэ мэт сонин дэвтэр гарсангүй тул хүн бүр түүнийг авч үзвээс хэрэгтэй болох учир Нийслэл Хүрээн дэх манай сонин бичгийн хороонд бэлтгэсэн дэвтрүүд буй. Үнэ нь 15 мөнгө болох учрыг тодорхойлон сонсгосугай»⁶ гэж бичсэн байна. Энэ сонордуулгаас үзвэл уг номын эрэлт хэрэгцээ их байсан, бас дээр өгүүлсэнчлэн шашныхан хуурмагаар худалдан авч устгасан зэрэгээс олдоц муутай болсон зэрэг шалтгаанаар тун их удалгүй дахин хэвлэсэн байж болзошгүй байна. Энд эргэлзэж болохуйц хоёр зүйл байгаа нь нэгд: номын нэрийг «Ертөнцийн байдал» гэсэн, хоёрт: зохиогчоор зөвхөн Ж.Цэвээнийг нэрлэсэн баримт юм. Гэвч энэ нь «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр»-ээс өөр шинэ ном гарч, түүнийг Ж.Цэвээн зохиосон хэрэг биш, зөвхөн сонины зарлалд үг хэмнэхийн үүднээс өмнөх номын нэрийн гол утга, зонхилон зохиогчийг дурдсан хэрэг гэж үзвэл зохино.

Ардын засаг тогтсоны дараа «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр»-ийг Ардыг гэгээрүүлэх яамнаас эрхлэн бага сургуулийн танхимд үзэх сурах бичиг болгож олон хувиар хэвлэж байсан нь уг номын ач холбогдол, эрэлт хэрэгцээ ямар байсныг харуулдаг. Академич Б.Ринчен энэ тухай дурсаж «Миний бие Алтанбулаг хотноо ардын төрийн үед анх байгуулсан бага сургуульд тэр бичгээр (Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр) дэлхийн байдал зэрэг хичээлийг зааж байсан билээ»⁷ гэсэн байдаг.

Ж.Цэвээн, Буяндалай нарын «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» гэдэг ном тэгсхийгээд дарагдаж хоцорсон биш, Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудад уттал хэрэглэгдэж, залуу үеийг сурган

хүмүүжүүлэхэд их тус болжээ. Уг ном хожим гарсан одон орны судлал, дэлхийн болоод Монголын газар зүй, ургамал судлалын зэрэг сурах бичгүүдээд суурь дэвсгэр болж өвлөгдсөн гэж үзэх үндэстэй. Түүнчилэн Монголын сэтгүүл зүйн үндсийг тавьсан «Шинэ толь хэмээх бичиг» сонины гэгээрүүлэх шинжийг өргөхөд уг ном зонхилох үүрэгтэй байв. Тус сонинд нийтлэгдэж байсан дэлхийн ертөнцийн тухай танин мэдэхүйн шинжтэй цуврал нийтлэлийн олонхыг «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр»-ээс хэсэглэн авдаг байсан нь нэгэнт тодорхой болжээ.

Тиймээс Ж.Цэвээн, Буяндалай нарын зохиосон «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» хэмээх бүтээлийг Монголын сэтгүүл зүйн практикт шинжлэх ухааны нийтлэг бичлэгийг үүсгэн төлөвшүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн нийтлэлийн бүтээл гэж үзвэл зохино. Тус дэвтрийн агуулгыг «Шинэ толь хэмээх бичиг»-т хэсэглэн нийтэлж байсан нь нэгд: өнөөгийн бидний үздэгээр уг сониныг соён гэгээрүүлэгч шинжтэй болгосон, хоёрт: дараа дараагийн сонин сэтгүүлүүдэд соён гэгээрүүлэгч шинжтэй нийтлэлийг уламжлал болгон авч явахад анхны үлгэр жишээг үзүүлсэн, гуравт: хожим шинжлэх ухааны сурталчилгааг дагнасан тогтмол хэвлэл гаргах эхний санаа сэдлийг төрүүлсэн анхдагч бүтээл мөн гэж үзүүштэй байна.

Ишлэл

¹ Норовсүрэн Л. 1993. Түүхэн үнэнийг хүндэтгээ. «Сэтгүүлч». №93.

² Норовсүрэн Л. 1996. Ж.Цэвээн — Монголын чөлөөт сэтгүүл зүйг үндэслэгч мөн. МУИС-ийн ЭШБ. (Нийгмийн ухаан). №2 (115).

³ Баасансүрэн Т. 2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ.

⁴ Цэвээн Ж. Түүвэр зохиолууд. I, II дэвтэр. 1997, 2009.

⁵ 1918. «Мүгдэнгийн монгол сэтгүүл». 11 дүгээр сарын 16. №15.

⁶ 1915. «Нийслэл хүрээний сонин бичиг». Есдүгээр сарын нэгэн. №1.

⁷ Ринчен Б. 1977. «Бурханы ном дэлгэрсэн улсуудад жуулчилсан бичиг» номын оршил үг. УБ., 5 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Бира Ш. 1960. Монгольская тибето-язычная историческая литература. (XVII-XIX вв.). УБ.

2. Владимирцов Б. Я. 1920. Монгольская литература. «Литература Востока». Вып. 2. Пб.

3. Грумм-Гржимайло Г. Б. 1926. Западная Монголия и Урянхайский край. Т. 3. Л.

4. Савельев. 1856. Хуандийн эртний судлалын нийгэмлэгийн Дорно дахины салааны бүтээл. (Орос хэлээр). СПб.

5. Шофман А. С. 1956. Казанский период жизни и деятельности Доржи Банзарова. СПб.

6. Баасансүрэн Т. 2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. Тэргүүн дэвтэр. I хэсэг. УБ.

7. Норовсүрэн Л. 2004. Монголын нийтлэл. Тэргүүн дэвтэр. УБ.

8. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл. (Нэмэн засварласан гурав дахь хэвлэл). УБ.

Summary

The article covers a work titled "Notes on Present situations around the Universe", written by Tseveen, J 100 years ago. It's dedicated to prove that the article was the founding stone of scientific fiction article in the Mongolian journalism. In addition, it has been mentioned that the quotations of the article has been published in Inner and Outer Mongolian media and used as textbooks in the first primary schools.